



ITG International Takhi Group
Freunde des Wildpferdes

Олон улсын тахь групп-ийн байр суурь

Олон улсын тахь групп (ITG) нь Монгол Улсын Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэгт орших Нарансэвстэй хилийн боомтыг дахин нээх шийдвэрийг эрс эсэргүүцэж байна. Учир нь уг шийдвэр нь уг бүсийн онцгой экосистем, ховор ургамал амьтанд бодит аюул занал учруулна.

ГИДЦГ-ын “А” хэсгийн ач холбогдол

Говийн Дархан Цаазат Газар нь 1975 онд байгуулагдсан бөгөөд энэ нь дэлхий даяар том хэмжээний дархан цаазат газруудыг байгуулах жишиг болсон түүхэн үйл явдал юм. Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэг нь 4.6 сая га талбайг хамардаг бөгөөд Монгол Улсад хамгийн хүн ам сийрэг бүс нутаг юм. Энэхүү уудам, алслагдсан, хүний нөлөө бага экосистем нь байгалийн жам ёсны үйл явц саадгүй явагдах боломжийг олгож, дэлхийд ховор амьтад болох Мазаалай, Хавтгай тэмээ зэрэгт амьдрах таатай орчныг бүрдүүлдэг.

Нарансэвстэй хилийн боомтыг нээхийн үр дагавар

Нарансэвстэй хилийн боомтыг 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс нээхээр төлөвлөжээ. Энэхүү боомт нь Монгол, Хятадын хилийн дагуу, ГИДЦГ-ын “А” хэсгийн дотор байрладаг. Боомтыг баруун хил дагуу 220 км урт замаар дотоодын сүлжээнд холбох төлөвлөгөө гарсан бөгөөд уг замын маршрут нь дархан цаазат газрын хил дотор байх юм.

Тус боомт өмнө нь 1992–1993 онд нээгдэж байсан бөгөөд тухайн үед машин тээврийн хөдөлгөөнөөс үүдсэн сөрөг нөлөө нь орон нутгийн ховор амьтдын тоо толгойд муугаар нөлөөлж байсныг харуулсан байдаг. Харин өнөө үед уг нөлөө бүр ч нэмэгдэх эрсдэлтэй. Орчин үеийн экспортын боомт байгуулахын тулд хатуу хучилттай зам, дэд бүтэц, том хэмжээний хилийн байгууламжууд шаардагдах тул хүний оролцоо, хөдөлгөөн эрс нэмэгдэх нь тодорхой. Үүнээс шалтгаалан тухайн газар хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, ГИДЦГ-ын “А” хэсгийн дундуур богино замууд бий болох магадлал өндөр байна.


Зэрлэг амьтад үзүүлэх нөлөө

ГИДЦГ-ын “А” хэсгийн орчин нь онцгой хатуу ширүүн нөхцөлтэй тул ургамал, амьтан тусгай дасан зохицолд оршиж, амьд үлдэх чадвараа хөгжүүлсэн байдаг. Ийм орчинд гарч буй аливаа сөрөг өөрчлөлт, хүнээс үүдэлтэй үймээн, амь нөөцийн бууралт нь амьдрах чадварт шууд заналхийлнэ.

Энд дэлхийд цор ганц үлдсэн Мазаалай амьдардаг бөгөөд нийтдээ ердөө 30 орчим тоо толгойтой нэн ховор зүйлийн нэг юм. Тэдний амьдрах орчин хязгаарлагдвал устгах аюулд орно.

Мөн дэлхий дээр үлдсэн гурван популяцийн нэг болох Хавтгай тэмээний амьдрах бүс нутаг ч мөн ГИДЦГ-ын “А” хэсгийн нийт нутаг, түүнчлэн хил орчим нутаг оршдог бөгөөд хүний аливаа нөлөөнд маш мэдрэмтгий зүйл юм.

ГИДЦГ-ын “А” хэсэг нь нүүдлийн зүйлүүдийн чухал амьдрах орчин бөгөөд хавтгай тэмээ, хулан, цагаан зээр, аргаль, цоохор ирвэс, мануул, шилүүс зэрэг Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенц (CMS)-ийн хүрээнд бүртгэгдсэн олон ховор амьтныг хамгаалж байдаг. Хэрэв уул уурхайн чиглэлтэй зам гарвал эдгээр нүүдлийн зүйлүүдийн шилжилт хөдөлгөөн Монголын дотоодод болон Монгол-Хятадын хил дамнасан байдлаар таслагдана.



ITG International Takhi Group
Freunde des Wildpferdes

ITG нь 30 гаруй жилийн турш Монголд Тахь (Пржевальскийн адуу)-ны сэргээн нутагшуулалтын ажлыг дэмжиж ирсэн. Бидний алсын хараа: *Төв Азийн тахийн тархаж байсан улс орон, ялангуяа Монгол Улстай урт хугацааны итгэлтэй хамтрагч, чадварлаг түнш байх. Үүний хүрээнд тахь болон түүний амьдрах орчныг хамгаалж, шаардлагатай нөхцөлд хамгаалалтын бүс нутгуудын экологи сүлжээг бэхжүүлэх, шинээр бүрдүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах.* Энэ хүрээнд бид Монголын Говийн томоохон газар нутгуудыг (Говийн их, бага дархан цаазат газрууд болон тэдгээрийн орчны бүсийн байгалийн нөөц газар болон байгалийн дурсгалт газруудыг) **Дэлхийн байгалийн өвд** бүртгүүлэх Монгол Улсын санаачилгыг бүрэн дэмжиж ажиллаж байгаа.

Говийн экосистемд үзүүлэх нөлөө

Говийн цөлийн экосистем нь олон зүйл, ялангуяа том хөхтөн амьтдын дэлхийд үлдсэн цөөн тооны орогнох газар нутаг билээ. Хэрэв Нарансэвстэй боомтыг нээгдвэл Говийн дөрвөн дархан цаазат газрын хамгийн том нь болох “А” хэсгийн экосистемийн бүрэн бүтэн байдалд ноцтой нөлөө үзүүлнэ. **Мазаалай, Хавтгай тэмээний тоо тогой цөөрөх, нэг мөсөн устгах аюулд орж,** олон арван жилийн турш хийгдсэн хамгааллын ажлын үр дүн устгах эрсдэлтэй. Мөн уг боомтыг дахин нээх нь **Говийн бүс нутгийг Дэлхийн байгалийн өвд бүртгүүлэх санаачилгыг бүрмөсөн зогсоох аюултай.**

Бидний хамгийн гол санаа зовж буй зүйл бол Нарансэвстэй боомт нь:

- *Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг бууруулж,*
- *ГИДЦГ-ын “А” хэсгийн онгон, хүний нөлөө багатай байдлыг алдагдуулж,*
- *Мазаалай баавгай, Хавтгай тэмээ зэрэг зүйлүүдийн устгах магадлалыг нэмэгдүүлж,*
- *Монгол болон хил дамнасан хамгаалалтын бүсүүдийн хооронд зэрлэг амьтдын нүүдлийн холбоосыг таслан зогсоох аюултай.*

Иймд бид Монгол Улсын Засгийн газарт Нарансэвстэй боомтыг нээх шийдвэрээ нухацтайгаар дахин авч үзэхийг хүсье.

Хүндэтгэсэн,
Олон улсын Тахь Групп (ITG)

Доктор Райнхард Шнидриг
Олон улсын Тахь Группийн Ерөнхийлөгч
